

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-11-03

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 11 дугаар сарын 11-ний “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Дүүргийн төсвөөс нийслэлд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлаа эрчимжүүлэх.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2025 онд хийхээр төлөвлөсөн ажлуудаа эрчимжүүлж, иргэд, олон нийтэд сурталчлах.	Дүүргийн ААНБ
3	Авто тээврийн шалган бүртгэх товчоод, маршрутын бус замаар Улаанбаатар хот руу түүхий нүүрс нэвтрүүлэхгүй байх, сайжруулсан шахмал түлш гаргахгүй байхад хяналт тавих.	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг
4	Барилгын талбайгаас гарч буй том оврын тээврийн хэрэгсэлд холбогдох хууль тогтоомж стандарт, норм дүрмийг мөрдүүлж, хяналт тавих.	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг
5	“Хотула” аппликейшний үйл ажиллагаа, хөгжүүлэлтийг жигдрүүлж, нийслэлийн байгууллагуудын удирдлагууд болон албан хаагч нар хэрэглэж хэвших, мэдээлэл солилцдог байх.	Дүүргийн ААНБ, Хэвлэл мэдээлэл
6	АТГ, ЭЦА-ны ЭЗГХТГ-аас зохион байгуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудтай холбоотой худалдан авах ажиллагааны талаарх сургалтад идэвхтэй хамрагдах.	Худалдан авах ажиллагаа
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
7	Цас орохоос өмнө нийтийн эзэмшлийн гудамж, талбай болон байгууллагууд ойр орчмын 50 метр газартаа түүвэр цэвэрлэгээ	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ

	хийх	
8	Малчдын зөвлөгөөн зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах	Дүүргийн менежер, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хороод, Мал эмнэлгийн тасаг
9	Архивын улсын үзлэгт бэлтгэх, бэлэн байдалд анхаарах	ИТХ, ЗДТГ, Багахангайн Үйлдвэрлэл технологийн парк ХК, Архивын хэлтэс
10	Аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхийн халаалтын ирэх, буцах шугамд хэмжилт хийх, тогтмол хяналт тавих, танилцуулах	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
11	Соёлын ордны барилгын ажлын тендэр зарлах	Худалдан авах ажиллагааны алба
12	Эрүүл мэндийн төвийн анализатор хүлээн авах ажлын хэсэг байгуулах	ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс
13	91 дүгээр сургуулийн цэвэр усны асуудлыг шийдвэрлэх	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, УСАТ
14	ТЭС петролиум шатахуун түгээх станцын сольсон бродюрыг хураалгах, хяналт тавих	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
15	Боловсролын байгууллагуудын багш нарын ажил хаялттай холбоотойгоор дүүргийн Засаг даргын “Цалинтай чөлөө олгох тухай” А/231 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хувийн хэвшлийн байгууллагуудад уриалга хүргүүлэх	Нийгмийн хөгжлийн хэлтэс, дүүргийн ААНБ
16	Орон сууцуудын В1 давхрын цонхны амлагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлын талаар албан бичиг боловсруулан хүргүүлэх	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
17	Хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламж бий болгох ажлын зардлын тооцоог гаргах, танилцуулах.	Дүүргийн менежер, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
18	Багахангай-2040 бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгааны тайланг дүүргийн сайтад байршуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ